



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар A/262

Арвайхээр

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт малын шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт ажлыг 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Мал эмнэлгийн ерөнхий газраас баталсан шимэгчтэх өвчний төлөвлөлтийг “Мал эмнэлгийн нэгдсэн систем”-д оруулж технологит хугацаанд нь чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн дарга, Мал эмнэлгийн анхан шатны үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (А.Нямдаваа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ТАНБОЛД

011100581